



**Монгол хүний мөн чанарын онолын загвар:
Constructivist Grounded Theory арга зүйд суурилсан судалгаа**

Итгэл Миэжэв 

Монгол Улсын Их Сургууль

<https://journal.mnier.mn>

Санал болгож буй эшлэл:

Итгэл, М. (2025). Монгол хүний мөн чанарын онолын загвар: Constructivist Grounded Theory арга зүйд суурилсан судалгаа. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 30(2).

<https://doi.org/10.56380/mjer.v30.2.1>

**The Theoretical Model of the Mongolian Person's
Essence: A Study Based on Constructivist
Grounded Theory Methodology**

Itgel Miyejav 

National University of Mongolia

To cite this article:

Miyejav, I. (2025). The Theoretical Model of the Mongolian Person's Essence: A Study Based on Constructivist Grounded Theory Methodology. *Mongolian Journal of Educational Research*, 30(2).

<https://doi.org/10.56380/mjer.v30.2.1>

The International Journal of Studies in Education and Science (IJSES) is a peer-reviewed scholarly online journal. This article may be used for research, teaching, and private study purposes. Authors alone are responsible for the contents of their articles. The journal owns the copyright of the articles. The publisher shall not be liable for any loss, actions, claims, proceedings, demand, or costs or damages whatsoever or howsoever caused arising directly or indirectly in connection with or arising out of the use of the research material. All authors are requested to disclose any actual or potential conflict of interest including any financial, personal or other relationships with other people or organizations regarding the submitted work.



This is an open access article under the Creative Commons Attribution-NonCommercial-ShareAlike 4.0 International License.



Монгол хүний мөн чанарын онолын загвар: Constructivist Grounded Theory арга зүйд суурилсан судалгаа

Миеэжавын Итгэл

Өгүүллийн мэдээлэл	ХУРААНГУЙ
Түүх: Хүлээн авсан: 2025.06.09 Засаж сайжруулсан: 2025.06.24 Хэвлэхийг зөвшөөрсөн: 2025.06.27 Түлхүүр үг: Монгол хүн, Ёс суртахуун, Бие, Сэтгэл, Оюун, Хэл, Бэлгэдэл	Удиртгал Энэхүү судалгаа нь ‘Монгол хүн гэж хэн бэ?’ гэсэн суурь асуултад эмпирик өгөгдөлд тулгуурлан онолын загвараар хариулахыг зорьсон. Хүний мөн чанарын ойлголт олон соёлын философи, антропологи, сэтгэл судлалын судалгаанд чухал байр суурь эзэлж ирсэн ч Монгол хүний өвөрмөц илэрхийллийг системтэйгээр шинжилсэн эмпирик ажил ховор байна. Арга зүй Constructivist Grounded Theory арга зүй ашиглан 30 оролцогчтой ярилцлага хийв. Тэднийг зургаан насны бүлэгт (15-17, 18-24, 25-34, 35-49, 50-64, 65+) болон оршин суух таван байршилд (баг, сум, аймаг, хот, гадаад) хуваасан түүврийг сонгосон. Өгөгдлийг open, focused, axial, theoretical кодчиллын дарааллаар шинжлэв. Үр дүн Судалгааны үр дүнд таван гол талбар илэрсэн нь: Бие, Сэтгэл, Оюун, Хэл, Бэлгэдэл бөгөөд эдгээрийг нэгтгэн зангидах төв ойлголт нь Ёс суртахуун байв. Эдгээр зургаан бүрэлдэхүүнийг нэгтгэсэн цөм ойлголт нь “Монгол хүн” бөгөөд энэ нь уламжлалд суурилсан дотоод ухамсар ба глобал нөхцөлд бэхэжсэн өөрийн тэнцвэрээр илэрхийлэгдэж байна. Дүгнэлт Энэхүү судалгаа нь Монгол хүний мөн чанарыг тайлбарлах онол- арга зүйн суурь өгч, үндэсний бодлого, ёс суртахууны боловсрол, соёлын боловсролын хэрэглээнд хувь нэмэр оруулна. Цаашид уг загварыг тоон аргаар баталгаажуулах судалгаа хийх шаардлагатай байна.



Энэхүү өгүүлэл нь Creative Commons Attribution-NonCommercial ShareAlike 4.0 Олон улсын лицензээр хамгаалагдсан болно

Холбоо барих зохиогч:

Миеэжавын Итгэл

Математикийн тэнхим, Монгол Улсын Их Сургууль

Мэйл хаяг: itgel@num.edu.mn

The Theoretical Model of the Mongolian Person's Essence: A Study Based on Constructivist Grounded Theory Methodology

Miyejav Itgel

Article information	ABSTRACT
Article history: Received: Jun 09, 2025 Revised: Jun 24, 2025 Accepted: Jun 27, 2025	Background This study aims to address the fundamental question, ‘Who is the Mongolian person?’ by constructing a theoretically grounded model based on empirical data. While the concept of human nature has occupied a central place in cross-cultural research within philosophy, anthropology, and psychology, empirical studies that systematically examine the distinctive expression of Mongolian personhood remain scarce. Method Adopting a Constructivist Grounded Theory methodology, we conducted in-depth interviews with 30 participants across six age groups (15-17, 18-24, 25-34, 35-49,

Keywords:

Mongolian Person, Morality, Body, Heart-Mind, Intellect, Language, Symbolism.

50-64, 65+) and five residential contexts (bag, sum, aimag, capital, overseas). Data analysis followed an open, focused, axial, theoretical coding sequence.

Findings

Results revealed five core domains- **Body (Embodiment), Heart- Mind (Emotional Essence), Intellect (Cognitive Mind), Language (Speech & Communication), and Symbolism (Cultural Representation)**- which are cohered by a central organizing concept of **Morality (Ethical Consciousness)**. These six components are integrated under the overarching core category of the “**Mongolian Person**”. This construct reflects a balance between tradition-rooted local identity and a globally reinforced self.

Conclusion

The study contributes a theoretical- methodological foundation for understanding Mongolian personhood, with implications for national policy, moral education, and cultural pedagogy. Future work should focus on quantitative validation to test and refine the proposed model.



This is an open access article under the Creative Commons Attribution-Non Commercial-ShareAlike 4.0 International License.

Corresponding author:

Miyevjav Itgel
Department of Mathematics, National University of Mongolia
Email: itgel@num.edu.mn

УДИРТГАЛ

XX зууны эхэн үеэс Монгол хүний онцлог, мөн чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах ажлын эхлэл тавигджээ (ШУА, 2021). Тодруулбал, 1920-1930 онд энэ чиглэлийн судалгаа аман зохиол, түүхийн ухаанаар эхэлж, 1931-1960 онд хэл шинжлэл, археологи, угсаатны зүй, эрүүл ахуйн салбараар өргөжжээ. Улмаар 1961-1991 онд хүн амын газарзүй, философи, социологи, эрүүл мэндийн судалгаагаар баяжиж, 1991 оноос хойш анагаах ухаан, боловсрол судлал, сэтгэл судлал, цэргийн шинжлэх ухаан, соёл, урлаг, соёл иргэншил зэрэг олон салбарт хүрээгээ тэлэн хөгжсөн байна.

XXI зуунд олон улсад хүн судлал (human studies)-ын салбар нь шинжлэх ухаан хоорондын уялдааг баримталж, феноменологийн болон герменевтик чиг хандлагад тулгуурлан философи, социологи, антропологи, түүх зэрэг салбарын огтлолцолд хөгжиж байна (Springer, n.d.). Монголын хүн судлал (Mongolian human studies) ч энэ өрнөлтэй хөл нийлүүлэн өргөжиж байгаа бөгөөд үүний тод жишээ нь сүүлийн жилүүдэд олон улсын хянан магадлагдсан сэтгүүлүүдэд нийтлэгдсэн бүтээлүүд юм.

Гэсэн хэдий ч “Монгол хүн гэж хэн бэ?” гэсэн суурь асуултын хариу өнөөг хүртэл үгүйлэгдсээр байна. Шинжлэх ухааны салбар бүрд өөр өөрийн үүднээс тайлбарласан олон бүтээл гарсан ч Монгол хүний нэгдмэл онолын хүрээ хараахан бүрдээгүйг эрдэмтэд тэмдэглэжээ. Жишээлбэл, академич Чулуунбаатар (2022) өнөөдрийн нийгэмд Монголчуудын ёс суртахууны асуудлын талаар өгүүлээд философийн онол-арга зүйн талаас нь судлах шаардлагатай гэж дүгнэжээ. Систем судлаач Бадарч (2022) “бид өнөөг хүртэл өрнөдийн философид хөтлөгдөж ирлээ. Үндэсний философигүй явж ирсэн учраас Монгол хүнийг төлөвшүүлж чадахгүй, монгол ч биш, дэлхийн ч биш хүн гаргаж байна” хэмээн шүүмжилсэн байдаг. Мөн академич Бэгз (2024) “монгол үндэстнийхээ мөн чанар, сэтгэлгээний онцлогийг танин мэдэх ажил хангалтгүй байна” гэж дүгнэсэн бол профессор Дарьхүү (2024) нар “Монгол хүн гэж хэн бэ?” гэсэн асуудлаар олон салбарын нэгдмэл судалгаа байхгүй байгааг онцолж, суурь судалгааг хөгжүүлэх шаардлагатайг цохон тэмдэглэжээ.

Өөрөөр хэлбэл, салбар бүрийн хүрээнд онолын бүтээлүүд гарсан ч ерөнхий цогц онолын хүрээ шинээр байгуулах асуудал тулгараад байна. Үүнтэй төстэй нөхцөл байдал 1950-аад онд Монголын уран зохиол судлалд гарч байсныг академич Дамдинсүрэн (1957, х.5) тодорхой бичсэн байдаг. Түүнийг эх хувилбараар нь сийрүүлье. Тэрээр “... тодорхой сэдвээр ном, гарын авлага байгаа боловч, нэгдмэл агуулгатай ном ховор буюу байгаа ном зохиолыг бүрэн үзэж чадаагүй зэргийн олон дутагдал надад байна. Ийм үед хоёр арга байна. Эхнийх нь уран зохиолын дурсгалт бичгүүдийг тус тусад нь сайн судалж олон бүтээл хэвлүүлээд дараа нь хураангуйлан товчилж бичих арга юм. Энэ бол хамгийн сайн арга мөн боловч ойрын 10-20 жилд дуусгаж чадмааргүй юм. Тэгвэл өөр арга хэрэгтэй. Урьдаар хураангуй тоймыг бичээд, сүүлд нь дурсгалт бичиг тус бүрийг задалж нягтлан шинжлэх нэг арга юм. Хураангуй тоймыг бичсэн хүн нэлээд алдаа хийж олон зүйлд осолдож магадгүй юм. Гэвч

тэр алдаа ослыг хойшид засаж болох бөгөөд түүнийг хамтын хүчээр засаж арилгах хэрэгтэй” гэж тэмдэглэсэн байдаг. Ингээд хоёр дахь аргыг ашиглан *Монголын уран зохиолын тойм* (1957) бүтээлийг зохиожээ.

Тэгвэл өнөөдөр ийм нөхцөл Монголын хүн судлалд үүссэн байна. Монгол хүний талаар олон салбарт олон бүтээл байгаа боловч тэдгээрийг нэг бүрчлэн цогц хэлбэрээр хураангуйлна гэвэл их хугацаа шаардах ажээ. Иймээс зохиогч энэхүү судалгаанд “Монгол хүн”-ийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тоймлон тодорхойлох аргыг эрэлхийлсэн юм.

Олон улсын хүн судлалын салбарт уламжлалт онол төвтэй (theory-driven) концепцээс гадна туршлагаас онол үүсгэдэг (experience-driven) чиг хандлага хүчтэй хөгжиж байна. Үүний төлөөлөл нь эмпирик өгөгдөлд суурилсан Grounded Theory (GT) арга зүй юм (Glaser & Strauss, 1967; Corbin & Strauss, 1990; Charmaz, 2006). Тус судалгаанд энэхүү арга зүйн нэг хувилбар болох Constructivist Grounded Theory (CGT) арга зүйг сонгон хэрэглэсэн бөгөөд энэ нь оролцогчдын өгүүлэмжийг нарийвчлан шинжилж, кодчиллын шат дарааллаар онолын шинэ загвар бүтээхэд чиглэдэг (Charmaz, 2014). CGT нь урьдчилсан таамаглалыг зөвхөн батлах эсвэл үгүйсгэхэд бус, харин эмпирик өгөгдлөөс шинэлэг онол үүсгэх боломжийг олгодог тул Монгол хүн гэж хэн бэ? гэдгийг “Монгол хүнээс нь онол байгуулах” замаар тодорхойлох давуу талтай. Ингэснээр орчин үеийн нийгэм-соёлын нөхцөл дэх Монгол хүнийг тодорхойлогч түлхүүр хүчин зүйлс, шинж чанаруудыг илрүүлж, тэдгээрийн уялдаа холбоог онолын загвараар дүрслэн харуулах боломж бүрдэх юм.

Иймээс энэхүү судалгааны зорилго нь урьдчилсан таамаглалд баригдалгүйгээр, эмпирик өгөгдөлд тулгуурлан туршлагаас урган гарсан онолын загвар бүтээхэд оршино. Тухайлбал, Монгол хүний мөн чанарын онцлогийг орчин үеийн нөхцөлд шинээр тайлбарлах онолын суурь бүтээхийг зорьсон юм.

Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах гурван асуултаар чиглүүлсэн болно. Үүнд:

1. Монгол хүний мөн чанарыг бүрдүүлэх боломжтой бүрэлдэхүүнүүд юу вэ, тэдгээрийг хэрхэн илрүүлж болох вэ?
2. Илэрсэн бүрэлдэхүүнүүдийн хооронд ямар зохион байгуулалт, харилцаа байна вэ?
3. Цөм ойлголт нь илүү өргөн орчинтой ямар байдлаар холбогдож болох вэ?

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Хүн судлалын судалгааны тойм

Хүний мөн чанарын асуудал нь философи, нийгмийн ухаан, антропологийн суурь асуултын нэг байсаар иржээ. XX зууны философийн онолчид хүнийг зөвхөн биологийн төдийгүй, өөрийн мөн чанараараа нийгэм-соёлын цогц оршихуй гэж тодорхойлжээ. Жишээлбэл, Scheler (1928) хүнийг зөвхөн амьд биет бус, сүнслэг мөн чанартай оршихуй (*spiritual being*) гэж үзсэн бол Heidegger (1962) хүнийг “ертөнцөд оршигч” (*being-in-the-world*) гэж тодорхойлсон нь хүний мөн чанарыг зөвхөн биологийн бус, харин оршихуйгаа утгачилж, өөрийгөө бүтээдэг шинж чанартай гэж тайлбарласан. Cassirer (1944) хүнийг тэмдэгт бүтээгч (*symbol-making animal*) хэмээн тодорхойлсноор хүний мөн чанарыг соёл ба тэмдэгтийн ертөнцөд авч үзжээ. Мөн Mead (1934) хүний мөн чанарыг нийгмийн харилцаанд төлөвшдөг (*socially emergent in interaction*) гэж үзсэн бол Geertz (1973) соёлыг утга учрын систем (*system of meaning*) хэмээн тайлбарлажээ. Эдгээр онолчдын үзэл санаа нь хүний мөн чанарыг биологийн хүрээнээс давуулан нийгэм, соёл, тэмдэгтийн орчинд авч үзэх онолын үндсийг бүрдүүлжээ.

Тэгвэл XXI зуунд хүний мөн чанарын судалгаа улам гүнзгийрч, олон салбарын огтлолцолд хөгжиж байна. Орчин үеийн философид хүний мөн чанарыг тогтсон, хатуу чанар бус харин утга, туршлага, түүхэн нөхцөлд өөрчлөгдөж байдаг шинж чанартай гэж үзэх хандлага давамгайлж байна (Taylor, 1991; Ricoeur, 1992). Нийгмийн ухаанд хүнийг глобалчлал, мэдээллийн эрин, технологийн шилжилтийн нөлөөгөөр олон түвшний мөн чанартай оршихуй гэж тодорхойлох болсон (Beck, 2000; Appadurai, 1996). Мөн когнитив шинжлэх ухаан, тархи судлал, хиймэл оюун ухааны огтлолцолд хүний мөн чанарыг зөвхөн соёл, нийгмийн хүрээнд бус танин мэдэхүйн, биотехнологийн, хиймэл оюун ухааны уялдаатай шинэ нөхцөлд тайлбарлах боллоо (Varela, Thompson, & Rosch, 1991; Harari, 2016). Ийнхүү XXI зуунд хүний мөн чанарын тухай ойлголт улам олон төвтэй болж, нийгэм-соёл, танин мэдэхүй, технологийн нэгдлийг багтаасан, өргөн хүрээний онолын асуудал болон өргөжиж байна.

Монгол хүн судлалын судалгааны тойм

XX зуунд Монголын хүн судлалын хөгжлийн түүхэнд анхдагч гэж хэлж болох дараах суурь бүтээлүүд цаашдын судалгааны чиг хандлагад үнэтэй хувь нэмэр оруулсан гэж хэлж болно. Үүнд: *Монголын уран зохиолын зуун билиг оршой* (Дамдинсүрэн, 1959), *БНМАУ-ын угсаатны зүй I, II боть* (Ред. Х. Бадамхатан, 1987, 1996), *Хүн судлал (антропологи)* 526, 57в, 57г (ШУА, 2006), *Угсаатан судлал, хүн судлалын удиртгал* (Орч. С. Дулам, 2007), *Монголчуудын эрдэм ухааны уламжлал* (Гонгоржав, 2008), *Хүн алдрын гайхамшиг I, II, III боть* (Балхаажав, 2016), *Нийгэм-соёлын хүн судлалын онолын үүд* (Бум-Очир, Мөнх-Эрдэнэ, 2018) зэрэг бүтээлийг дурдаж болно. Мөн 1991 онд Монгол Улсын Анагаах Ухааны Их Сургуулийн дэргэд Хүн судлалын үндэсний төв байгуулагдаж, доктор Батсуурийн удирдлага дор Монголын хүн амын генетик, морфологи-физиологи-биохими, хүн ам судлал гэсэн гурван үндсэн чиглэлээр судалгаа өрнөсөн нь шинжлэх ухааны институцийн түвшинд хүн судлалыг хөгжүүлэх шинэ шат болсон (ШУА, 2006, 526). Улмаар 2006 онд Монгол хүн судлалын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын зорилтыг тодорхойлсон бөгөөд энэ хүрээнд дараах таван салбар чиглэлийг онцлон хөгжүүлэхээр төлөвлөсөн байна (ШУА, 2006, х. 45-46). Үүнд: Монгол хүний нийгмийн төрх судлал, Монгол хүний генетик, Монгол хүний морфологи, физиологи, биохими, Монгол хүн ам зүй, Эртний Монгол хүн судлал ба угсаатны зүй юм.

XXI зуунд Монгол хүн судлал олон улсын шинжлэх ухааны чиг хандлагатай уялдан хөгжих боллоо. Постмодерн ба герменевтик философийн нөлөөгөөр хүнийг соёл, утга, туршлагын сүлжээнд авч үзэх хандлага давамгайлж, нийгмийн ухаанд глобалчлал ба технологийн эринд хүний (*multiple identities*) онцлогуудыг олон түвшинд судалж байна (Appadurai, 1996; Beck, 2000). Монголын хүн судлалын судалгаанд ч энэ өрнөл тусгалаа олж, хүн судлал, философи, социологи, сэтгэл судлал, боловсрол судлал, анагаах ухаан зэрэг олон салбарт өргөжин хөгжиж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Дариймаа (Marav, 2022), Буяндэлгэр, Мөнгөнтуул (Batmunkh & Enkhbat, 2024), Баттүвшин нар (Lkhagvasuren et al., 2024), Өсөхболд (Usukhbold et al., 2025), Заяасүрэн нар (Chuluun et al., 2025) зэрэг олон улсын өндөр эрэмбэтэй сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлүүд Монгол хүнийг судлахын зэрэгцээ нийгэм, соёл болон танин мэдэхүйн онцлогийг онол-арга зүйн шинэчлэлтэй холбон тайлбарлахад чиглэсэн байна. Үүнээс гадна когнитив шинжлэх ухаан, хиймэл оюун ухаан, тархи судлалын уялдаа нэмэгдэж, Монгол хүний оршихуй, мөн чанарыг зөвхөн угсаатны болон соёлын хүрээнээс гадна танин мэдэхүйн ба технологийн өргөн орчинд шинээр тайлбарлах боломжийг олгож байна.

XXI зуунд Монгол хүн судлалын хүрээнд олон салбарын эрдэмтэд өөр өөрийн үүднээс Монгол хүний онцлог, мөн чанарыг тайлбарлах бүтээлүүдийг Монгол хэл дээр туурвисан байна. Эдгээрийг агуулгын хувьд зохиогч гурван үндсэн чиглэлд эмхтгэн авч үзэв. Үүнд:

Философийн чиглэлд: Монгол хүний мөн чанар, сэтгэлгээний онцлогийг философийн хүрээнд судалсан бүтээлүүд чухал байр суурь эзэлдэг. Жишээлбэл, Профессор Даш-Ёндон (2019) Монголын хөгжлийн үзэл баримтлалын суурь хүчин зүйлсийг онолын түвшинд авч үзсэн, Академич Нарангэрэл (2020) Монголчуудын нийгмийн ёс суртахууны асуудлыг Монгол хүний төлөвшилтэй холбон тайлбарлажээ. Доктор Пүрэвсүрэн (2009) хэл ба соёлын уялдаа холбоог онцлогийн түвшинд шинжилсэн нь Монгол хүнийг танин мэдэх онолын шинэ суурь болж байна. Мөн Академич Жадамба нар (2023) хүний хандлагын бүтцийг уламжлалт соёл талаас нь тайлбарласан нь Монгол хүний зан төлөвийн судалгаанд шинэ бүтээл болжээ.

Нийгмийн ба соёлын чиглэлд: Монгол хүний хөгжлийн асуудлыг шинжлэх ухаан, нийгмийн шинжлэх ухааны хүрээнд авч үзсэн бүтээлүүдийг авч үзье. Профессор Цанжид (2024) Монголын төр, шинжлэх ухаан, бизнесийн хамтын ажиллагааны гурамсан загварт тулгуурлан “хөгжлийн улс” гэсэн шинэ үзэл баримтлалыг дэвшүүлэхдээ Монголын судлаачдыг чадавхжуулах бодлого тодорхойлсон байна. Академич Бэгз (2024) Монгол хүний хөгжил, төлөвшлийн асуудлыг философийн хандлагаар тайлбарласан бол профессор Төмөр-Очир (2024) нийгэм ба боловсролын тогтолцооны социал талуудыг дүгнэж, хүний хөгжилд үзүүлэх нөлөөллийг онцолсон байна.

Боловсролын чиглэлд: Боловсрол судлалын хүрээнд Монгол хүний суралцахуйн онцлог, чадамж, дүр төрхийг тодорхойлох судалгаанууд гарсан нь онцлог байна. Профессор Пүрэв (2019) Монгол хүний суралцахуйн үнэт зүйлийг дөрвөн бүрэлдэхүүн хэсэгтэй гэж тодорхойлсон бол профессор Оюунцэцэг нар (2020) XXI зууны Монгол суралцагчийн цогц чадамжийг мөн дөрвөн хэсэгтэйгээр

тайлбарлажээ. Тэгвэл Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн баг (Итгэл нар, 2024) Монгол суралцагчийн дүр төрхийг таван бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлсон нь боловсролын орчинд Монгол хүний төлөвшлийн онцлогийг системтэй харуулах оролдлого болж байна.

Ийнхүү философи, нийгэм-соёлын болон боловсролын чиглэлд хийгдсэн олон судалгаа нь Монгол хүний тухай ойлголтыг салбар бүрийн хүрээнд тайлбарлаж байгаа ч эдгээрийн үр дүнг нэгтгэн бүхэлд нь хамарсан цогц онолын хүрээ хараахан бүрдээгүй байна. Тиймээс өнөөгийн нөхцөл дэх “судалгааны цоорхой” нь олон улсын чиг хандлагад нийцэхүйц, эмпирик өгөгдөлд тулгуурласан, CGT-ийн аргаар боловсруулсан Монгол хүний мөн чанарын цогц онолын загвар дутагдаж буйд оршино.

Энэ нь “Монгол хүн гэж хэн бэ?” гэсэн суурь асуултад шинжлэх ухааны түвшинд иж бүрэн, системтэй хариулт боловсруулах шаардлагыг улам бүр тодотгож буйг харуулна. Өөрөөр хэлбэл, салбар хоорондын ололт, онолын тайлбаруудыг нягтруулан нэгтгэж, олон өнцгөөс өгөгдсөн тайлбарыг бүхэллэг онолын түвшинд зангидах эрэлт хүчтэй тулгарч байна.

Энэ хүрээнд зөвхөн академик судалгааны бүтээлүүд бус, философийн өгүүлэмж, эсээ, хувь хүний дүгнэлт хэлбэрийн бүтээлүүд ч чухал лавлагаа болж байна. Жишээлбэл, сэтгүүлч Эрдэнийн *Их сурвалжин: Угшил ба оргил* (2002) нь үндэсний угшил, соёл, оюун санааны тухай эргэцүүлэл дэвшүүлсэн бол, философич Дашнямын *Дэлхийжиж яваа дэгдээхэй дүү нартаа* (2009) нь хүмүүнлэгийн сургааль, үндэсний ухамсрын асуудлыг залуу үед чиглүүлэн өгүүлжээ. Физикч Цоохүүгийн *Монгол хүн: Та хэн бэ?* (2015) бүтээлд монгол хүний хэв шинжийг 15 суурь ойлголтоор тодорхойлсон бол, зохиолч Номинчимэдийн *Монголоо нэхэж буй Монгол* (2018) нь ёс зүй, нийгмийн ухамсрын өнөөгийн асуудлыг түүх, уламжлалтай холбон тайлбарласан байна. Үүнчлэн доктор Одхүүгийн *Монгол менталитет* (2019) нь малчин ахуйд суурилсан сэтгэлгээний өвөрмөц хэв шинжийг авч үзсэн бол, зохиолч Түдэвийн *Үгэн мөндөр, Үгэн бороо, Үгэн шуурга* (2021) бүтээлүүд нь нийгмийн өөрчлөлт дундах үнэт зүйлсийг эргэцүүлэн сургамжилжээ. Мөн зохиолч Аюурзанын *Монгол хүн гурван цуврал* (2023) нь үндэсний үзэл, хуудам бичиг, түүхэн сурвалжийг хүний мөн чанартай холбон өгүүлсэн бол, доктор Дэмбэрэлийн *Монголын боловсрол өнөө ба ирээдүй* (2023) нь боловсролын чанар, шинэчлэл, үндэсний үнэт зүйлсийг ирээдүйн хүмүүжил, төлөвшлийн асуудалтай холбон авч үзсэнээрээ онцлогтой юм. Эдгээр бүтээлүүд нь шинжлэх ухааны судалгааны бүтээл биш боловч монгол хүний мөн чанарын тухай соёл, ёс суртахуун, нийгмийн ухамсар, боловсролын талаарх чухал сэтгэхүйн эх сурвалж болж байна.

Иймээс XXI зууны Монгол хүн судлал нь уламжлалт антропологийн хязгаарыг даван, шинжлэх ухаан хоорондын уялдаа болон олон төвтэй онол-арга зүйн чиг хандлагад түшиглэн хөгжих шаардлагатай болжээ. Энэ нь зөвхөн Монгол хүнийг тодорхойлох асуудлыг гүнзгийрүүлэхээс гадна глобал түвшний хүн судлалын өрнөлтэй уялдуулан, философи, социологи, антропологи, боловсрол, когнитив шинжлэх ухаан зэрэг олон салбарын огтлолцолд шинэлэг онолын хандлагаар хөгжих боломжийг нээж байна.

АРГА ЗҮЙ

Судалгааны дизайн

Энэхүү судалгаанд чанарын судалгааны арга зүй болох (CGT)-ийн дизайн хэрэглэв. Энэ нь оролцогчдын үзэл бодол, туршлагад тулгуурлан шинэ онолын загвар дэвшүүлэхэд тохиромжтой бөгөөд өгөгдлийг шат дараатай кодлож, байнгын харьцуулалтын аргаар судлах онцлогтой (Charmaz, 2014).

Оролцогчид

Судалгаанд чанарын зорилтот түүврийн аргыг ашиглаж судалгааны асуултад хамгийн сайн хариулт өгч чадах, холбогдох туршлага, мэдлэгтэй оролцогчдыг шилэн сонгов (Charmaz, 2006). Түүврийн хувьд оролцогчид насны ялгаатай бүлэг бүрээс төлөөлөлтэй байх, мөн амьдарч буй газрын хувьд олон талт байдлыг хангах зарчим баримталсан. Насны ангиллыг шат дараалан өргөтгөж, онолын ханалт хангасан гэж үзсэн зургаа дахь ангилалд түүвэрлэлт дуусав. Судалгаанд хамруулсан насны ангиллууд нь насны бүлгүүд бөгөөд ярилцлагыг ахмадаас залуу үе рүү буюу 65+, 50-64, 35-49, 25-34, 18-24, 15-17 гэсэн дарааллаар авч, хийсэн. Харин газар зүйн хувьд амьдардаг таван (баг, сум,

аймаг, хот, гадаад) байршлыг судалгаанд хамруулсан. Ингэснээр нийт 30 оролцогчтой түүвэр бүрдэв (Хавсралт 1).

Мэдээлэл цуглуулалт

Мэдээлэл цуглуулах үндсэн арга нь ярилцлага (in-depth interview) байв. Энэ арга нь цөөн тооны оролцогчоос тухайн сэдвийн талаар нарийн, гүнзгийрүүлсэн мэдээлэл авах боломжийг олгодог (Creswell & Poth, 2018). Судалгааны оролцогчдын газарзүйн байршлын онцлогоос шалтгаалан зарим ярилцлагыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Нийтдээ 2101 минут буюу ойролцоогоор 35 цагийн ярилцлага хийсэн бөгөөд оролцогч бүрийн ярилцлагын хугацаа 30-125 минутын хооронд хэлбэлзэж, дундаж нь 70 минут байна.

Ярилцлага нь хоёр үе шаттайгаар явагдсан. Эхний үе шатанд оролцогч өөрийгөө танилцуулах, чөлөөтэй яриа өрнүүлэх бэлтгэл хэсэг багтсан бөгөөд энэ нь итгэлцэл бий болгох, нээлттэй хуваалцах уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэсэн. Үүний дараа үндсэн хэсэгт шилжиж, насны ангилал бүрээс таван оролцогчтой ярилцсан. Анхны ярилцлагуудаас гарсан open coding-ийн үр дүнд үндэслэн асуултуудыг шат дараатайгаар шинэчилж, focused coding болон theoretical coding-д хүрэх арга зүйгээр боловсруулсан. Ийнхүү асуултыг үе шаттайгаар нарийсган хөгжүүлсэн нь судалгааны гол ойлголтууд болон онолын загварыг тодруулах боломжийг бүрдүүлэв. Асуултын жишээг Хавсралт 2-т үзүүлэв.

Өгөгдлийн шинжилгээ

Өгөгдлийг CGT-ийн хандлагаар шинжилсэн бөгөөд кодчиллын үйл явц Charmaz (2014)-ийн зааврыг голчлон баримталсан. Судалгааны зорилго болон өгөгдлийн онцлогоос хамаарч уламжлалт шатлалыг уян хатан байдлаар хэрэглэв.

Эхний шат буюу **open (initial) coding**-д ярилцлага, тэмдэглэл, баримт бичгээс олон төрлийн түлхүүр санаа илэрч, өргөн хүрээтэй, заримдаа давхардсан байдлаар бүртгэгдсэн. Дараагийн шатанд эдгээр санааг ангилж, нягтруулан нэгтгэж **focused coding** хийсэн бөгөөд ингэснээр өгөгдлийн дийлэнх санааг төлөөлөхүйц таван үндсэн ангилал тодорсон. Үүний дараа **axial coding** ашиглаж, таван ангиллын уялдаа холбоо болон харилцан хамаарлыг шинжлэх явцад эдгээрийг нэгтгэн зангидаж буй төв ойлголт нь **ёс суртахуун** болох нь тодорхой болсон. Ёс суртахуун нь зөвхөн нэг талбарт бус, бүх ангилалд шингэсэн цөмийн үүрэгтэй байв. Сүүлийн шатанд **theoretical coding** ашиглан ангилал ба төв ойлголтыг илүү өргөн хүрээний, бүхэллэг онолын тайлбар болгон өргөтгөсөн. Энэ шатны үр дүнд илэрсэн цөм ойлголт нь **“Монгол хүн”** байсан бөгөөд өмнөх бүх код, ангиллыг нэгтгэн зангидаж, Монгол хүний мөн чанарыг илэрхийлэх онолын тайлбар болж төлөвшсөн.

Ингэснээр энэхүү судалгаанд кодчиллын шатлал нь: **open → focused → axial → theoretical coding** гэсэн дарааллаар өрнөсөн юм. Судалгааны туршид **“байнгын харьцуулалтын арга”** хэрэглэж, шинэ өгөгдлийг өмнөхтэй харьцуулан баталгаажуулав. Өгөгдлийн олон талт байдлыг хангаж, зургаа дахь насны ангиллын түвшинд шинэ санаа гарахгүй давхардаж байсан тул **онолын ханалт (theoretical saturation)** болсон гэж үзэж өгөгдөл цуглуулах ажлыг өндөрлөв.

Үр дүнгийн баталгаажуулалт

Судалгааны үр дүнгийн үнэн зөв, найдвартай байдлыг хангахын тулд боловсруулсан кодчиллол болон урьдчилсан дүгнэлтийг олон чиглэлийн мэргэжилтнүүдтэй тус бүр уулзан зөвлөмж авсан. Үүнд боловсрол судлал, эдийн засаг, философи, систем судлал, сэтгэл судлал, социологийн чиглэлийн судлаач, мэргэжилтнүүдтэй уулзаж, өөр өөрийн өнцгөөс өгсөн үнэлгээ, зөвлөмжийг тусган судалгааны үр дүнгээ сайжруулж байв. Энэ үйл явц нь судалгааны итгэл үнэмшил, найдвартай байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой (Lincoln & Guba, 1985) болсон юм.

Судалгааны ёс зүй

Энэхүү судалгааг олон улсын судалгааны ёс зүйн зарчимд тулгуурлан зохион байгуулсан. Оролцогчдыг сайн дурын үндсэн дээр хамруулж, судалгаанд оролцох зөвшөөрөл авсан. Судалгааны зорилго, агуулга, оролцогчийн эрх, өгөгдөл ашиглах нөхцөлийг урьдчилан тайлбарласан. Ярилцлагын явцад өгөгдлийг тэмдэглэлээр цуглуулсан бөгөөд түүнийг зөвхөн судалгааны зорилгоор ашигласан. Оролцогчдын нэр, хувийн мэдээллийг нууцалж, зөвхөн кодоор тэмдэглэн, аюулгүй байдлыг хангав. Судалгааны явцад оролцогчдод ямар нэгэн сэтгэлзүйн дарамт, хор хөнөөл

учруулахгүй байх зарчим баримталсан. Судалгааны ёс зүйн үндэс нь олон улсын **Belmont Report (1979)**-ын гурван зарчим (хүн бүрийг хүндэтгэх, хор хөнөөлөөс ангид байлгах, шударга байх) болон чанарын судалгааны итгэлцлийн шалгуур (credibility, transferability, dependability, confirmability)-ыг тодорхойлсон **Lincoln & Guba (1985)**-ийн хандлагад тулгуурласан. Мөн судалгаа нь МУИС-ийн Судалгааны ажлын ёс зүйн журам (2024)-ын шаардлагад нийцүүлэв.

Хязгаарлалт

Чанарын зорилтот түүврийн онцлогоос шалтгаалан судалгааны үр дүнг нийт хүн амыг төлөөлөн дүгнэх боломжгүй юм. Гэсэн хэдий ч насны зургаан ангилал болон амьдардаг таван байршлын төлөөллийг хамруулснаар өгөгдлийн олон талт байдлыг хангаж, онолын ханалтын түвшинд хүрсэн гэж үзэж байна.

ҮР ДҮН

Энэхүү судалгааны зорилго нь “Монгол хүн хэн бэ?” гэдгийг үе үеийн төлөөллөөс ярилцлагаар илрүүлж, онолын түвшинд загварчлахад чиглэсэн. CGT-ийн аргачлалын дагуу өгөгдлийн кодчиллыг open→focused→axial→theoretical coding гэсэн шат дарааллаар хийв.

Open coding: *Эхний түлхүүр санаанууд*

Ярилцлага, тэмдэглэл, баримт бичгээс олон тооны түлхүүр санаа илэрсэн. Эдгээр санаа нь заримдаа давхардсан, заримдаа утга ойролцоо байсан ч Монгол хүний тухай олон талт туршлага, ойлголтыг илэрхийлж байв.

Focused coding: *Таван үндсэн талбар*

Эхний шатанд илэрсэн олон санааг нягтруулан нэгтгэхэд дараах **таван талбар** тодорсон. Эдгээр талбар бүр нь оролцогчдын амьдралын туршлага, хэлсэн үгсээр баталгаажсан бөгөөд жишээгээр илүү тод харагдана. Ийм жишээ хангалттай олон байна. Бид онолын ханалтыг харуулах зорилгоор талбар бүрд зөвхөн хоёрыг түүвэрлэн оруулсан болно.

Бие: Хөдөлмөр ба тэсвэрийн илрэл

Оролцогчдын хувьд “бие” нь зөвхөн биеийн хүч бус, шударгаар хөдөлмөрлөх, тэсвэртэй байх чадварыг илэрхийлж байв. Жишээлбэл:

- “Ажилдаа тэсвэртэй байж, өдөр бүр малдаа сааль хийж байж л амьдрал явдаг. Хөдөлмөргүй хүн Монгол хүн гэж хэлэхэд хэцүү” (K06).
- “Математикийн бодлого бодох нь заримдаа биеийн хөдөлмөрөөс ч хэцүү санагддаг. Гэхдээ зөв хариугаа өөрөө олох нь миний хөдөлмөр” (K28).

Бие нь хөдөлмөр, тэсвэрийн туршлагаар илэрч, үе тус бүрийн нөхцөлд өөр өөрөөр тайлбарлагдсан ч нийтлэг утгаараа ажилсаг, тууштай байх ёс суртахууны талбар болж байна.

Сэтгэл: Хүнлэг чанарын илрэл

“Сэтгэл” нь хүнлэг чанар, бусдад туслах, харилцан дэмжих хандлагыг илэрхийлэв. Үүнийг оролцогчид дараах байдлаар тодорхойлжээ:

- “Өөрт ашиггүй ч бусдад тусалсан нь жинхэнэ сэтгэл юм” (K03).
- “Гадаадад сурч байхдаа хэцүү үедээ бусад Монгол оюутнуудтайгаа ярилцаж, урам авдаг. Энэ нь намайг Монгол хүн гэдгээ мэдрэх хамгийн том зүйл” (K25).

Сэтгэл нь үеийн ялгаатай нөхцөлд өөрөөр илэрсэн ч нийтлэгээрээ энэрэнгүй, хүнлэг чанарыг төлөөлж байна.

Оюун: Ухамсарт мэдлэгийн талбар

Оролцогчид “оюун”-ыг мэдлэгээ зөв ашиглах, ухамсартай шийдвэр гаргах чадвар гэж ойлгож байлаа. Тухайлбал:

- “Зөвхөн мэдлэгтэй байгаад хангалтгүй, тэр мэдлэгийг зөв шийдвэр гаргахад ашиглаж чаддаг байж л Монгол хүний үнэт зүйл бүрдэнэ” (K07).
- “Математик бодох нь зөв шийдвэр гаргах дасгал гэж боддог. Энэ чадвар маань Монголдоо хэрэг болно гэж найдаж байна” (K29).

Оюун нь зөвхөн мэдлэг хуримтлуулах бус, түүнийг ухамсартайгаар хэрэглэх, зөв шийдвэр гаргах чадвараар илэрч хэрэглээний чадамжаар Монгол хүний үнэ цэнийг тодорхойлдог.

Хэл: Харилцааны талбар

Монгол хэл нь зөвхөн харилцааны хэрэгсэл бус үндэсний үнэт зүйлийг хадгалах суурь гэж тайлбарлагдав. Оролцогчид дараах байдлаар онцолжээ:

- “Монгол хэл бол миний сэтгэлгээний үндэс. Найзуудтайгаа монголоор ярьж, зохиол уншиж байж би өөрийгөө Монгол хүн гэж мэдэрдэг” (K28).
- “Англиар их ярьдаг ч тэмдэглэлээ монголоор бичихийг хичээдэг. Монгол хэлээрээ сэтгэхгүй бол өөрийгөө жинхэнэ Монгол хүн гэж мэдрэхгүй” (K25).

Хэл нь Монгол хүний үнэт зүйлийг хадгалж, соёлын ухамсрыг дамжуулах гол талбар юм.

Бэлгэдэл: Бахархлын талбар

“Бэлгэдэл” нь уламжлалт болон орчин үеийн хэлбэрээр илэрч, бахархал, шударга өрсөлдөөн, хамтын ухамсрыг илэрхийлэв. Үүнийг оролцогчид дараах байдлаар илэрхийлсэн:

- “Цагаан сар, Наадам бол Монгол хүний хамгийн том бэлгэдэл. Монгол дээлээ өмсөхөд л би өөрийгөө жинхэнэ Монгол хүн гэж мэдэрдэг” (K01).
- “Дүрэмт хувцас бол зөвхөн ажил биш, Монгол төрийн нэр хүндийн бэлгэдэл. Шударга байхын илрэл” (K24).

Бэлгэдэл нь үеийн онцлогоос үл хамааран Монгол хүний бахархал, үнэт зүйлсийг илэрхийлэх чухал талбар юм.

Axial coding: Ёс суртахуун - Монгол хүний төв шинж

Өгөгдлийн уялдаа холбоог шинжлэх axial coding-ийн шатанд бүх талбарыг нэгтгэн зангидаж буй төв ойлголт нь “**ёс суртахуун**” болох нь тодорхой болов. Ёс суртахуун нь ахмад, дунд, залуу үеийн алинд ч нийтлэг илэрч, үнэнч шударга байдал, хариуцлага, итгэл даах чанараар тодорхойлогджээ.

- “Хүн алдаа гаргаж болно, гэхдээ худал хэлж болохгүй. Үнэнээ хэлэх нь хүнийг хүн болгож, Монгол хүний нэрийг авч явдаг” (K04).
- “Шударга байна гэдэг нь амласнаа биелүүлэх гэсэн үг. Найз нөхдөдөө итгэл даадаг хүн байхын тулд шударга байхыг хичээдэг” (K26).
- “Би ахлах сургуульд багшилдаг. Заримдаа хүүхдүүд бага зэрэг бэрхшээлтэй тулгарахад амархан арга хайдаг. Би тэдэнд үнэнчээр хөдөлмөрлөж олсон амжилт хамгийн их үнэ цэнэтэй гэдгийг ойлгуулахыг зорьдог. Сурагчид маань шударгаар бие даан төслөө хамгаалж, өөрийн хүчээр олсон үр дүнгээрээ бахархаж байхыг харах нь багш хүний хувьд хамгийн том урам юм” (K14).

Ёс суртахуун нь зөвхөн нэг талбарт хязгаарлагдахгүй, харин бүх шинжийг чиглүүлж, зангидаж буй төв код болж, Монгол хүний мөн чанарын гол тулгуур болж байна.

Theoretical coding: “Монгол хүн” цөм ойлголт

Theoretical coding-ийн шатанд өмнөх бүх талбар, төв ойлголтыг нэгтгэн зангидахад “**Монгол хүн**” хэмээх цөм ойлголт тодорлоо. Энэ ойлголт нь хоёр түвшинд зэрэг илэрч байна.

- **Дотоод ухамсар (local identity):** уламжлал, ахуй, үндэсний хувцас, ахмадын сургаалаар баталгаажсан ухамсар.
 - “Монгол дээл өмсөхөд өөрийгөө Монгол хүн гэдгээ улам их мэдэрдэг” (K29).
 - “Морь унахдаа монгол хувцсаа өмсөхгүй бол нэг л сонин. Харин өмсөхөөрөө энэ нутгийн хүн гэдгээ мэдэрдэг” (K11).
 - “Ээж минь ‘Монгол хүн байна даа, буцалж байгаа цайнаас уугаад яваарай’ гэдэг байсан” (K2).
- **Глобал ухамсар (global self):** гадаад орчин, боловсрол, олон улсын туршлагаар бэхэжсэн ухамсар.
 - “Түүхийн хичээл дээр XXIII зуун бол Монголын зуун гэж багш хэлэхэд Монгол хүн гэдгээрээ бахархсан” (K30).
 - “Чи гадаадад олон жил болсон ч Монголоо алдаагүй байна. Ахмадаа хүндлэх ёс чамд байна гэж өвөө хэлсэн” (K20).

- “Монголын За, Андгай буй За’ гэдгийг их сургуульд ойлгож, энэ нь Монгол хүний хариуцлага, үгээ биелүүлэхийн сургаал байсныг ухаарсан” (K09).

“Монгол хүн” цөм ойлголт нь локал (уламжлал, ахуйд суурилсан) болон глобал (гадаад орчин, боловсролоор бэхэжсэн) ухамсрын тэнцвэр дээр оршиж, Монгол хүний мөн чанарыг бүхэлд нь тодорхойлов.


Онолын ханалт

Насны бүлгүүдийн харьцуулалт нь кодын тогтвортой илрэл, шинэ санааны баяжилтыг харуулсан бөгөөд зургаа дахь бүлгийн түвшинд (15-17 нас) шинэ код илрээгүй. Иймээс өгөгдөл онолын ханалт (theoretical saturation)-д хүрсэн гэж үзэв.

Судалгааны үр дүнг нэгтгэн харвал “Монгол хүн” нь бүх кодыг нэгтгэх цөм тодорхойлж байна (Зураг 1).

- Зургаан талбар (Ёс суртахуун, Бие, Сэтгэл, Оюун, Хэл, Бэлгэдэл) нь үе үеийн нөхцөлд өөр өөрөөр илэрсэн ч нэгэн нэгдмэл утгаар соёлын бүтцийг бүрдүүлэв.
- Бүх талбарыг зангидаж буй төв ойлголт нь “ёс суртахуун”, харин цөм ойлголт нь “Монгол хүн” юм.
- Энэ “Монгол хүн” нь локал болон глобал ухамсрын тэнцвэр дээр оршиж, Монгол хүний мөн чанарыг илүү бүрэн тодорхойлж байна.

Зураг 1. Монгол хүний мөн чанарын онолын загвар



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгааны зорилго нь Монгол хүний мөн чанарын онолын загварыг CGT-ийн арга зүйгээр боловсруулахад чиглэсэн юм. Судалгааны үр дүнд **Theoretical code** нь “Монгол хүн”, **Axial code** нь “Ёс суртахуун”, харин **Focused codes** нь *Бие, Сэтгэл, Оюун, Хэл, Бэлгэдэл* болох нь тогтоогдлоо. Иймээс Монгол хүний мөн чанар нь **Ёс суртахуун төвтэй таван талбарын систем** болж, нийтдээ зургаан бүрэлдэхүүнээс бүрдэх онолын загвар боловсруулагдлаа.

Энэхүү загварын цөм нь “Монгол хүн” гэсэн код бөгөөд энэ нь дотоод (local identity) ба гадаад (global self) хоёр түвшинд зэрэг илэрч, Монгол хүний өөрийн тухай ойлголтыг үндэсний болон дэлхийн хүрээнд нэгэн зэрэг тайлбарлах боломжийг нээж байна. “Ёс суртахуун” нь системийн тэнхлэг болж, Бие, Сэтгэл, Оюун, Хэл, Бэлгэдэл нь түүнийг илэрхийлэх таван талбарын хэмжээс болж байна.

Дэлхийн сонгодог онолын гурван чиглэлтэй харьцуулахад, **философи-онтологи чиглэлд** хүнийг оюун ухаант, оршихуйн асуулт тавьж чадах оршихуй гэж үздэг (Plato, 1997; Heidegger, 1962), **нийгэм-соёлын чиглэлд** хүнийг нийгмийн харилцаа, хэл, соёл дотор бүрэлдэнэ гэж тайлбарладаг (Marx & Engels, 1978; Vygotsky, 1978), харин **экзистенциал-хувь хүн төвтэй чиглэлд** хүнийг үйл хөдлөл, сонголтоороо мөн чанараа бүтээдэг гэж үздэг (Sartre, 1992; Maslow, 1968). Энэхүү судалгааны үр дүн эдгээр чиглэлтэй уялдаж, Монгол хүний мөн чанарын онол нь нэг талаас дэлхийн суурь парадигмуудад нийцэж байгааг, нөгөө талаас өвөрмөц бүтцээрээ ялгарч байгааг харууллаа.

Мөн бүс нутгийн соёлын уламжлалтай харьцуулахад, Европын уламжлалд хүнийг оюун ухаан, эргэцүүлэл, рациональ үйлдлээр тодорхойлдог (Aristotle, 1984) нь бидний онолын “Оюун” талбартай нийцэж байна. Азийн уламжлалд ёс суртахуун, нийгмийн зохирол, өрөвч нинжин сэтгэл давамгайлдаг (Confucius, 1997; Rahula, 1974) нь бидний онолын “Ёс

суртахуун, Сэтгэл”-ийн талбартай зохицож байна. Уугуул Америкийн уламжлалд хүнийг байгаль, хамтын оршихуй, сүнсний харилцаагаар тодорхойлдог (Cajete, 2000; Deloria, 2006) нь бидний загварын **“Бие, Сэтгэл”**-ийн агуулгатай дүйж байна. Уугуул Австралийн уламжлалд газар нутаг, (*Dreamtime*), домог-цаг хугацааны уялдаа голлодог (Stanner, 1979; Rose, 1992) нь Монголын **“Бие, Сэтгэл”**-ийн байгаль-оршихуйн тэнхлэгтэй нягт холбоотой. Африкийн Ubuntu философи хүний мөн чанарыг хамтын оршихуй, өвөг дээдсийн холбоонд тайлбарладаг (Mbiti, 1969; Ramose, 1999) нь бидний загварын **“Ёс суртахуун, Сэтгэл”**-ийн хэмжээсийг баталгаажуулж байна.

Иймд Монгол хүний мөн чанарын онол нь нэг талаас **дэлхийн сонгодог онолууд болон бүс нутгийн соёлын уламжлалтай нийцэж**, нөгөө талаас **Хэл, Бэлгэдэл** гэсэн бусад соёлд төдийлөн тод илрээгүй өвөрмөц талбаруудыг багтааснаараа судалгааны шинэлэг тал нь болно. Энэхүү онол нь Монголын философийн уламжлал (Балхаажав, 2016), ардын аман зохиол (Дашдорж, Ринчинсамбуу, 1964) болон орчин үеийн соёл-антропологийн онолуудтай (Geertz, 1973; Cassirer, 1944; Turner, 1967) нийцэж, эмпирик өгөгдлөөр баталгаажсан нь түүнийг онолын хувьд нотолж байна.

Үндэсний ба глобал ач холбогдол

Судалгаа нь үндэсний түвшинд Монгол хүний мөн чанарыг уламжлал ба орчин үеийн ойлголттой уялдуулсан шинжлэх ухааны загвар болж, боловсролын бодлого, хүүхдийн хүмүүжлийн хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил зэрэгт хэрэгжүүлэх боломжийг нээж байна. Харин глобал түвшинд, олон соёлын харьцуулалтад ашиглаж болох ёс суртахуун төвтэй хүний онолын загвар болж байна. Энэ нь Geertz (1973)-ийн соёл-антропологийн онол болон UNESCO (2015)-ын ёс суртахууны боловсрол чиг хандлагатай уялдаж, Монголын туршлагыг дэлхийн судалгаанд шинэ хувь нэмэр оруулж байна.

Онолын ханалтын баталгаа

Насны бүх бүлэг болон орчны бүх ангилалд ёс суртахуун төвтэй зургаан шинж тогтвортой илэрсэн нь онолын ханалтад хүрснийг нотолж байна. Ахмад үе уламжлалаа хадгалах, дунд үе хөдөлмөр ба мэдлэгийн ухамсарт хэрэглээг эрхэмлэх, залуу үе өдөр тутмын шударга зан, үнэнч харилцаагаар илэрхийлсэн нь судалгааны тогтвортой байдлыг баталлаа.

Хязгаарлалт ба цаашдын судалгаа

Судалгааны хязгаарлалтад оролцогчдын тоо (30 хүн) харьцангуй цөөн байсан, чанарын аргын онцлогоос шалтгаалан субъектив нөлөө орох боломжтой, зөвхөн Монгол хүнийг хамарсан зэрэг орно. Цаашдын судалгаанд:

- Тоон судалгаагаар баталгаажуулах,
- Талбар (бүрэлдэхүүн) бүрийн агуулгыг тодорхойлох, холбоо хамаарлыг судлах,
- Бусад соёлтой харьцуулсан олон соёлын судалгаа хийх,
- Боловсрол, хүмүүжлийн хэрэглээнд турших зэрэг чиглэлээр өргөжүүлэх боломжтой.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд CGT арга зүй ашиглан Монгол хүний мөн чанарыг системтэйгээр тодорхойлсон. Үр дүнд нь “ёс суртахуун” төвтэй, бие–сэтгэл–оюун–хэл–бэлгэдлийн таван талбар бүхий онолын загвар боловсруулав. Энэ загвар нь үндэсний болон олон улсын түвшинд Монгол хүнийг шинжлэх ухааны түвшинд цогцоор нь тайлбарласан анхны оролдлого гэж хэлж болох юм.

Судалгаанд оролцогчдын тоо 30 байсан нь үр дүнг нийт хүн амд шууд ерөнхийшүүлэхэд хязгаар учруулна. Чанарын аргын онцлогоос шалтгаалан судлаачийн байр суурь болон оролцогчдын субъектив үнэлгээ үр дүнд нөлөөлөх магадлалтай. Мөн судалгаа зөвхөн Монгол хүний контекстэд хязгаарлагдсан тул бусад соёлтой харьцуулах боломж бүрэн нээгдээгүй байна.

Энэхүү онолын загварыг тоон судалгаагаар баталгаажуулах шаардлагатай. Бусад орны жишээтэй харьцуулсан олон улсын судалгаа хийх нь Монгол хүний мөн чанарын онцлогийг илүү өргөн хүрээнд хөгжүүлэх болно. Мөн боловсролын бодлого, хөтөлбөр, багшийн мэргэжлийн хөгжил, суралцагчийн хүмүүжилд туршин хэрэглэх замаар практик үр нөлөөг үнэлэх боломжтой.

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгаанд оролцож, өөрийн үнэтэй цаг зав, мэдлэг, туршлагаа харамгүй хуваалцсан нийт оролцогчдод гүн талархал илэрхийлье. Та бүхний нээлттэй, чин сэтгэлийн хариулт, үнэтэй зөвлөмж, дурсамж, туршлагууд нь судалгааны үр дүн, онолын загварыг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан билээ. Мөн боловсрол, философи, сэтгэл судлал, социологи, эдийн засаг, системийн судлалын чиглэлээр мэргэжлийн үнэлгээ, зөвлөгөө өгсөн судлаач, мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

- Аюурзана, Г. (2023). *Монголын нууц товчоон дахь эрхэм чанар*. УБ: Гүн паблишн.
- Аюурзана, Г. (2023). *Монгол хүн: Худам бичгээс гүн сэтгэлгээ рүү*. УБ: Гүн паблишн.
- Аюурзана, Г. (2023). *Монгол хүн: Үндэсний үзэл бодол*. УБ: Гүн паблишн.
- Бадарч, Д., Найдандорж, Р., & Мөнххүж, Б. (2022). *Боловсролын их нүүдэл суудал*. УБ.
- Бэгз, Н. (2024). *Монголын боловсролын философи*. УБ. Соёмбо принтинг ХХК.
- Балхаажав, Д. (2016). *Хүн алдрын гайхамшиг (I-III боть)*. УБ.: Содпресс ХХК.
- Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ, Л. (2018). *Нийгэм-соёлын хүн судлалын онолын үүд*. УБ.: МУИС пресс хэвлэлийн газар.
- Гонгоржав, Д. (2008). *Монголчуудын эрдэм ухааны уламжлал*. УБ.: Сутра
- Дарьхүү, Р., & Оюунгэрэл, Д. (2024). Монгол хүний мөн чанарын асуудалд. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.si.2024.09>
- Дамдинсүрэн, Ц. (1959). *Монголын уран зохиолын зуун билиг оршвой*. УБ.:ШУ ба ДЭБХ
- Дамдинсүрэн, Ц. (1957). *Монголын уран зохиолын тойм*. УБ.: ШУА.
- Дашдорж, Ж., & Ринчинсамбуу, Г. (1964). *Монгол цэцэн үгийн далай (Дэвтэр 1)*. УБ.: ШУА.
- Даш-Ёндон, Б. (2019). *Монголын хөгжлийн философи* (Философийн шинжлэх ухааны докторын диссертаци). УБ.
- Дашням, Х. (2009). *Дэлхийжиж яваа дэгдээхэй дүү нартаа*. УБ: Адмон.
- Дэмбэрэл, Ц. (2023). *Монголын боловсрол өнөө ба ирээдүй*. УБ. Оюуны чадварын IQ төв.
- Жадамбаа, Б., Мөнхжаргал, Д., & Алтангоо, О. (2023). *Хандлага, түүний гурвал бүтэц*. УБ.: Түшиг дизайн ХХК.
- Итгэл, М., Отгонбаатар, Х., Санжаабадам, С., Туяа, У., Энхжаргал, Х., & Дэнсмаа, Ж. (2024). Монголын боловсролын тогтвортой хөгжүүлэх үзэл санаа. *Боловсролын судалгааны Монголын сэтгүүл*, 29(2). <https://doi.org/10.56380/mjer.v29.2.1>
- Копан, Ж. (2007). *Угсаатан судлал, хүн судлалын удиртгал*. (Орч. С.Дулам). УБ.: Битпресс.
- МУИС. (2024). *Судалгааны ажлын ёс зүйн журам*.
- Нарангэрэл, С. (2020). *Монголчуудын ёс суртахууны сэргэлт, ялзрал, эргэн сэргэлт*. УБ.: Жиком пресс.
- Номинчимэд, Б. (2018). *Монголоо нэхэж буй Монгол*. УБ.
- Одхүү, С. (2019). *Монгол менталитет*. УБ.: Адмон принт ХХК
- Оюунцэцэг, Н., Норжхорлоо, Н., & Мөнхжин, О. (2020). Монгол суралцагчийн цогц чадамжийн тохирцыг тандсан судалгааны үр дүнгээс. *Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг*, 133-145.
- Пүрэв, О. (2019). Боловсролын хүн судлал хийгээд Монгол хүний суралцах үнэт зүйлийн судалгаа. *Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бичиг*, 186–196.

- Пүрэвсүрэн, Б. (2009). *Хэлний онтологи агуулгын философи-соёлын харьцуулсан судалгаа* (Философийн докторын диссертаци). УБ.
- Төмөр-Очир, С. (2024). *Өнөөгийн Монгол боловсрол: Тулгамдсан социал асуудлууд, шийдвэрлэх арга зам*. УБ. Хангай дээд сургууль.
- Түдэв, Л. (2021). *Үгэн шуурга*. Шилдэг эсээ- I. УБ: “SAYAN” хэвлэлийн газар
- Түдэв, Л. (2021). *Үгэн бороо*. Шилдэг эсээ- II. УБ: “SAYAN” хэвлэлийн газар
- Түдэв, Л. (2021). *Үгэн мөндөр*. Шилдэг эсээ- III. УБ: “SAYAN” хэвлэлийн газар
- Цанжид, А. (2024). *Шинэ нөхцөл дэх шинжлэх ухаан, технологи, инновацын бодлого*. УБ.: Соёмбо принтинг.
- Цоохүү, Х. (2015). *Монгол хүн: Та хэн бэ?*. УБ.: Үсэг хоршоо.
- Чулуунбаатар, Г. (2022). Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт. *Монголын хөгжлийн философи, сэтгэлгээний өөрчлөлт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл*, 16–34.
- ШУА. (1987, 1996). *БНМАУ-ын угсаатны зүй*. I-II боть. (Ред. Х. Бадамхатан). УБ.: ШУА.
- ШУА. (2006). *Хүн судлал (антропологи)*: 52б, 57в, 57г. УБ.
- ШУА. (2021). *Монгол улсын шинжлэх ухааны түүх* (I-IV боть). (Ер.ред. Д. Рэгдэл). УБ.
- Эрдэнэ, Ч. (2002). *Их гурвалжин: Угшил ба оргил*. УБ: Адмон.
- Appadurai, A. (1996). *Modernity at large: Cultural dimensions of globalization*. Minneapolis, MN: University of Minnesota Press.
- Aristotle. (1984). *The complete works of Aristotle* (J. Barnes, Ed.). Princeton University Press.
- Beck, U. (2000). *What is globalization?* Cambridge: Polity Press.
- Cassirer, E. (1944). *An essay on man: An introduction to a philosophy of human culture*. New Haven, CT: Yale University Press.
- Charmaz, K. (2006). *Constructing grounded theory: A practical guide through qualitative analysis*. Sage.
- Charmaz, K. (2014). *Constructing grounded theory* (2nd ed.). Sage.
- Chuluun, Z., Batsaikhan, J., & Lkhagvadorj, T.-E. (2025). Cultural rituals for young children in Mongolia. *Journal of Education Culture and Society*, 16(2), 179-194. <https://doi.org/10.15503/jecs2025.3.179.194>
- Confucius. (1997). *Analects* (D. C. Lau, Trans.). Penguin Classics.
- Corbin, J., & Strauss, A. (1990). *Basics of qualitative research: Grounded theory procedures and techniques*. Sage.
- Creswell, J. W., & Poth, C. N. (2018). *Qualitative inquiry and research design: Choosing among five approaches* (4th ed.). Sage.
- Geertz, C. (1973). *The interpretation of cultures: Selected essays*. New York: Basic Books.
- Glaser, B., & Strauss, A. (1967). *The discovery of grounded theory: Strategies for qualitative research*. Aldine.
- Harari, Y. N. (2016). *Homo Deus: A brief history of tomorrow*. London: Harvill Secker.
- Heidegger, M. (1962). *Being and time* (J. Macquarrie & E. Robinson, Trans.). New York: Harper & Row. (Original work published 1927).
- Lincoln, Y. S., & Guba, E. G. (1985). *Naturalistic inquiry*. Sage.

- Lkhagvasuren, B., Hiramoto, T., Bat-Erdene, E., et al. (2024). Anxiety, depression, and brain overwork in the general population of Mongolia. *Scientific Reports*, 14, 2484. <https://doi.org/10.1038/s41598-024-52779-w>
- Marav, D. (2022). Mongolian pre-service English teachers' voices about their teaching practicum experiences. *Education Sciences*, 12(5), 339. <https://doi.org/10.3390/educsci12050339>
- Maslow, A. H. (1968). *Toward a psychology of being* (2nd ed.). Van Nostrand.
- Mbiti, J. S. (1969). *African religions and philosophy*. Heinemann.
- Mead, G. H. (1934). *Mind, self, and society from the standpoint of a social behaviorist*. University of Chicago Press.
- National Commission for the Protection of Human Subjects of Biomedical and Behavioral Research. (1979). *The Belmont report: Ethical principles and guidelines for the protection of human subjects of research*. U.S. Government Printing Office.
- Plato. (1997). *Complete works* (J. M. Cooper & D. S. Hutchinson, Eds.). Hackett.
- Rahula, W. (1974). *What the Buddha taught*. Grove Press.
- Ramose, M. B. (1999). *African philosophy through Ubuntu*. Mond Books.
- Ricoeur, P. (1992). *Oneself as another*. University of Chicago Press.
- Rose, D. B. (1992). *Dingo makes us human: Life and land in an Australian Aboriginal culture*. Cambridge University Press.
- Sartre, J.-P. (1992). *Being and nothingness* (H. Barnes, Trans.). Washington Square Press. (Original work published 1943).
- Scheler, M. (1928). *Die Stellung des Menschen im Kosmos* [The human place in the cosmos]. Darmstadt: Otto Reichl Verlag.
- Springer. (n.d.). *Human Studies: A journal for philosophy and the human sciences*. SpringerLink. Retrieved October 1, 2025, from <https://link.springer.com/journal/10746>
- Stanner, W. E. H. (1979). *White man got no dreaming: Essays, 1938-1973*. ANU Press.
- Taylor, C. (1991). *The ethics of authenticity*. Harvard University Press.
- Turner, V. (1967). *The forest of symbols: Aspects of Ndembu ritual*. Cornell University Press.
- UNESCO. (2015). *Global citizenship education: Topics and learning objectives*. UNESCO Publishing.
- Usukhbold, Ch., Anna, H., & Greg, T. (2025). The rhetoric of teacher quality: Neoliberal education reform in postsocialist Mongolia. *Globalisation, Societies and Education*. <https://doi.org/10.1080/14767724.2025.2543321>
- Varela, F. J., Thompson, E., & Rosch, E. (1991). *The embodied mind: Cognitive science and human experience*. MIT Press.
- Vygotsky, L. S. (1978). *Mind in society: The development of higher psychological processes*. Harvard University Press.

Зохиогчдын мэдээлэл

Овог, нэр: Миеэжавын Итгэл

 <https://orcid.org/0000-0001-9854-5604>

Байгууллагын нэр: МУИС, Математикийн тэнхим

Хаяг: 115 тоот, МУИС-ийн I байр, Их сургуулийн гудамж-1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот Улс: Монгол

e-mail: itgel@num.edu.mn

ХАВСРАЛТ 1.

Хүснэгт 1. Оролцогчдын товч мэдээлэл

Код	Насны ангилал	Хүйс	Оршин суудаг газар	Статус	Ярилцлагын хугацаа (мин)
K01	65+	эр	Хөдөө	Малчин, 87 нас	119
K02	65+	эр	Сум	Тариаланч, 78 нас	110
K03	65+	эм	Аймгийн төв	Олон хүүхэд өсгөсөн, 74 нас	105
K04	65+	эр	Нийслэл	Багш, 75 нас	98
K05	65+	эм	Гадаадад	Судлаач, 68 нас	102
K06	50–64	эм	Хөдөө	Саальчин, 52 нас	84
K07	50–64	эр	Сум	Банкны ажилтан, 50 нас	79
K08	50–64	эм	Аймгийн төв	Эмнэлгийн лаборант, 57 нас	88
K09	50–64	эм	Нийслэл	Нийгмийн ажилтан, 61 нас	91
K10	50–64	эр	Гадаадад	Орчуулагч, 51 нас	76
K11	35–49	эр	Хөдөө	Малчин, 49 нас	85
K12	35–49	эм	Сум	Сургуулийн захирал, 41 нас	78
K13	35–49	эр	Аймгийн төв	Бизнесмен, 38 нас	71
K14	35–49	эм	Нийслэл	Биологич, 48 нас	82
K15	35–49	эр	Гадаадад	Жолооч, 47 нас	69
K16	25–34	эм	Хөдөө	Багийн эмч, 29 нас	66
K17	25–34	эм	Сум	Оёдолчин, 32 нас	59
K18	25–34	эр	Аймгийн төв	Цахилгаанчин, 26 нас	54
K19	25–34	эр	Нийслэл	Тамирчин, 34 нас	62
K20	25–34	эм	Гадаадад	Эдийн засагч, 28 нас	72
K21	18–24	эр	Хөдөө	Цэрэг, 19 нас	49
K22	18–24	эр	Сум	Оюутан, 21 нас	52
K23	18–24	эм	Аймгийн төв	тогооч, 24 нас	46
K24	18–24	эр	Нийслэл	Цагдаа, 24 нас	57
K25	18–24	эм	Гадаадад	Оюутан, 23 нас	41
K26	15–17	эм	Хөдөө	Сурагч, 17 нас	44
K27	15–17	эм	Сум	Сурагч, 16 нас	38
K28	15–17	эр	Аймгийн төв	Сурагч, 15 нас	36
K29	15–17	эм	Нийслэл	Сурагч, 17 нас	42
K30	15–17	эр	Гадаадад	Сурагч, 16 нас	40

ХАВСРАЛТ 2.

Оролцогчдоос асуусан зарим асуултууд

Хэсэг I. Бэлтгэл хэсэг (бүх насны бүлэгт)

1. Өөрийгөө танилцуулах асуулт

- Та өөрийгөө товчхон танилцуулна уу? (нас, мэргэжил, хаана амьдардаг, юу хийдэг).
 - Та өөрийн нутгаа нэг үгээр тодорхойлох бол ямар үг хэлэх вэ?
2. Өөрийгөө нээх, дурсамж сэргээх асуулт
- Танай гэр бүл, нутагт хамгийн их хэрэглэдэг зүйр цэцэн үг юу вэ?
 - Багадаа хамгийн их тоглодог байсан тоглоом эсвэл дуртай заншлаа дурсаач.
 - Та өөрийгөө “Монгол хүн байна даа” гэж мэдэрч байсан өдөр тутмын жижигхэн тохиолдол санаанд орж байна уу?
3. Яриаг эхлүүлэх, сэдэв рүү чиглүүлэх асуулт
- Таны бодлоор Монгол хүнийг бусдаас ялгадаг нэг чанар юу вэ?
 - “Монгол хүн” гэдэг үг сонсоход хамгийн түрүүнд ямар дүр зураг санаанд ордог вэ?

Хэсэг II. Насны бүлэг бүрийн зарим асуултууд

1. 65+ насны бүлэг
- Таны бодлоор жинхэнэ Монгол хүн гэж хэнийг хэлдэг байсан бэ?
 - Өнгөрсөн үе, өнөө үеийн Монгол хүн ямар ялгаатай вэ?
 - Хүүхдүүдэд Монгол хүний мөн чанарыг үлдээхийн тулд юуг заавал дамжуулах хэрэгтэй гэж боддог вэ?
2. 50-64 насны бүлэг
- Танай орчинд Монгол хүн гэж юуг илүү чухалчилдаг байсан бэ?
 - Зүйр цэцэн үг, сургаалаас Монгол хүнийг хамгийн сайн илэрхийлсэн жишээ хэлнэ үү.
 - Социализм, ардчиллын өөрчлөлтүүд Монгол хүнд яаж нөлөөлсөн гэж үздэг вэ?
3. 36-49 насны бүлэг
- Ажил, хөдөлмөрийн орчинд Монгол хүн ямар байдлаар илэрдэг гэж боддог вэ?
 - Шинжлэх ухаан, боловсрол, технологийн хөгжил Монгол хүнд ямар шинэ зүйл нэмж өгсөн гэж боддог вэ?
 - Хүүхдэдээ Монгол хүн гэж нэг өгүүлбэрээр хэлбэл та юу гэж хэлэх вэ?
4. 26-35 насны бүлэг
- Та өөрийгөө Монгол хүн гэж мэдэрсэн хамгийн тод дурсамж юу вэ?
 - Глобал орчинд ажиллаж, амьдрах үед Монгол хүний мөн чанарыг хэрхэн хадгалж байна вэ?
 - Ирээдүйд хүүхдүүддээ юуг заавал дамжуулах ёстой гэж боддог вэ?
5. 19-25 насны бүлэг
- Та Монгол хүн байна гэж мэдрэхдээ хамгийн их бахархсан үйл явдал юу байсан бэ?
 - Танай үеийн залуусын хувьд Монгол хүнийг илэрхийлэх гол бэлгэдэл юу гэж боддог вэ?
 - Ирээдүйд Монгол хүний мөн чанарыг хадгалах боломж, сорилтыг та хэрхэн харж байна вэ?
6. 15-18 насны бүлэг
- Та өдөр тутмын амьдралдаа Монгол хүн байна гэдгийг хэрхэн мэдэрдэг вэ?
 - Үлгэр, домог, баатарлаг түүх таны хувьд Монгол хүний мөн чанартай хэрхэн холбогддог вэ?
 - Ирээдүйд та өөрөө хүүхдэдээ Монгол хүн гэж ямар зүйлийг заавал дамжуулна гэж бодож байна вэ?